



**НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар A/16

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллого, Засаг даргын Тамгын газрын хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.4, 71 дүгээр зүйл, 72 дугаар зүйлийн 72.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай” 09 дүгээр тогтоол, дүүргийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн “Дүүргийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг дүүрэгт зохион байгуулах салбар комисс байгуулах тухай” A/110 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 07 дугаар сарын 05-ны өдөр, Засаг даргын Тамгын газрын хагас жилийн тооллогыг 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 07 дугаар сарын 18-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсугай.

2.Тооллого зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.


3.Тушаалын хэрэгжилтийг хангаж үзлэг, тооллогыг тогтоосон хугацаанд дуусгаж, танилцуулах, тооцоо нийлэн, акт үйлдэхийг Ажлын хэсэг (Н.Оюунцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.БАТТУШИГ

Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын
Тамгын газрын даргын 2022 оны 05 дугаар сарын
06 -ны өдрийн 4/ дугаар тушаалын хавсралт



Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллого,
Засаг даргын Тамгын газрын хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг
зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Оюунцэцэг

(Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Гишүүд:

Ю.Баян-Очир

(Аж ахуйн тасгийн дарга)

М.Урнаа

(Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн ахлах
мэргэжилтэн)

М.Балжинням

(Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн
ахлах мэргэжилтэн)

Л.Ариунжаргал

(Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

Ж.Батбаяр

(Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн
мэргэжилтэн)

Б.Мөнхчимэг

(Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн
мэргэжилтэн)

С.Эрдэнэзаяа

(Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн
мэргэжилтэн)

Б.Батжаргал

(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн)

Э.Гуамарал

(Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн)

М.Цэндхорол

(Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

Г.Даваадулам

(Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

З.Эрдэнэцэцэг

(Засаг даргын Тамгын газрын тооцооны нягтлан
бодогч)

Л.Гантуяа

(Засаг даргын Тамгын газрын нярав)

Нарийн бичгийн дарга:

Э.Алтангэрэл

(Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

2022.05.06
10:00